

Н.ЗОЛЖАРГАЛ: УЛСТӨРЧИД СОНГУУЛИЙН ДАРАА АМЬДРАЛ, ЭДИЙН ЗАСАГ БАЙХГҮЙ ЮМ ШИГ ААШЛАХ НЬ АЮУЛЫН ДОХИО

Д.Жаргалсайхан энэ удаагийн de facto нэвтрүүлэгтээ Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргалыг урьж ярилцлаа.

-Та Монголын Хөрөнгийн биржид ажиллаж байсан. Хөрөнгийн бирж, Монголбанкинд ажиллахад зарчмын ямар ялгаа байна вэ?

-Хөрөнгийн биржид ажиллаж байхад социализмаас зах зээлийн эдийн засаг руу шилжсэн өөр үе байсан юм. Тэрхүү шилжилтийн үндэс суурь нь өмчлөлийг массын хувьчлал руу оруулсан явдал. Хувьчлалын үед хөрөнгийн бирж үнэт цаасны зах зээлийг зэрэг эхлүүлэх хариуцлагатай сонголт тулгарч байлаа. Үүнийг бид хариуцаж, улсын хэмжээний том асуудлыг шийдэхээр болсон. Богино хугацаанд их ажил хийж, үүнд олон мянган залуус оролцож байлаа. Харин өнөөгийн Монголын эдийн засагт Монголбанкны байр суурь нөлөө бүхий байна. Монголын нийт мөнгөний 90 гаруй хувь нь банкинд төвлөрсөн байна. Иймээс улсын хэмжээний ажил хийгдэж байгаагаараа хөрөнгийн биржтэй төсөөтэй. Гэхдээ үнэт цаасы зах зээлийг анх хөгжүүлж байхад хэцүү байсан. Энэ хоёрын хооронд 20 жилийн зөрүү байгаа учир улс оронд олон зүйл өөрчлөгдсөн л дөө.

-Улс орны эдийн засгийг хоёр жигүүртэй байдаг гэж үзвэл нэг нь мөнгөнийх, нөгөө нь хөрөнгийн зах зээл. Манай улсын хувьд мөнгөний зах зээлээр дагнаж ирсэн. Сүүлийн үед улстөрчид та нарыг эдийн засгийн буруутай этгээд гэж яриад байгаагийн учир нь юу вэ?

-Сонгууль дөхөөд ирэхээр улстөр-чид өөр хүн болчихдог юм байна. Монгол Улсын хуулийн түвшинд мөнгөний бодлогыг УИХ баталдаг. Үүнд аль болох чөлөөтэй хэлбэлзэнэ гээд тодорхой заасан байдаг. Төрийн оролцоог төсвөөрөө дамжуулан Засгийн газар оролцоно гэж заасан байдаг.

-Өнгөрсөн онд шатахууны үнэ нэмэгдэж, доллар төгрөгийн харьцаа муудсанд та бүхнийг буруутгаж байсан. Яагаад ингэсэн юм бол оо?

-Үүнийг нэг өдөр, нэг амьсгаагаар тайлбарлах сэдэв биш. Олон жилийн турш Засгийн газар шатахууны зах зээлд оролцсон. Ерөнхий сайд С.Баярын Засгийн газрын үед онцгой татварыг сулладаг системийг сонгосон. Ингэснээр дэлхийн зах зээлийн үнэ өсөх тусам онцгой татварыг бууруулдаг механизм руу орсон. Үүний дагуу өнгөрсөн жилийн хавар дэлхийн зах зээлд шатахууны үнэ өсч байхад жижиглэнгийн үнээ барихын тулд онцгой татварыг тэглэсэн. Ийнхүү онцгой татваргүй болж, дэлхийн зах зээлийн үнээр нэмэгддэг байсан шатахуунтай болоход ОХУ манай улсад экспортлодог татвараа нэмсэн. Иймд шатахуун импортлогчид 8-11сард шатахууны үнээ нэмэхийг хүссэн боловч зөвшөөрөөгүй. Ийм маягаар явж байгаад саяхан хамтарсан Засгийн газар салах үед үнэ нэмэх зөвшөөрлийг олгосон шүү дээ. Тооцоолоод үзсэн чинь 260 төгрөгөөр өссөн байсан. Дэлхийн ямар ч эрүүл эдийн засагтай улсад нэг шөнийн дотор шатахууны үнэ нь 260 төгрөг буюу 18 хувиар өссөн түүхийг би сонсоогүй. Энэ бол эдийн засгийн хамгийн том шок, сөрөг нөлөө. Үүний гарал үүсэл нь салбарын сайд болон Ерөнхий сайд С.Батболд анхааралгүй байснаас үүдсэн хэрэг биш. Гарал үүсэл нь өнгөрсөн хавар онцгой татвар тэглэсэнээс үүдсэн.

-Онцгой татвар байх ёстой юу тэгэхээр?

-Өнөөдөр бүх зүйлийг эргээд дүгнэхэд шатахууны үнийг хариуцдаг хүмүүс нь бид биш. Гэхдээ өдөр тутам хардаг зүйл бол өргөн хэрэглээний барааны үнэ юм. Үүнд л тохируулж бодлогоо явуулдаг. Гэтэл ямар асуудал үүсч байна гэхээр өргөн хэрэглээний барааны үнэд шууд нөлөөлдөг хамгийн чухал хэсэг буюу шатахууны үнэ нэг шөнийн дотор 18 хувиар өсөх нь эдийн засгийг маш том хямралд оруулж байгаа юм.

-Нэмэх заавал шаардлага байсан уу?

-Энэ талаар сар гаруйн хугацаанд олон тайлбар өгсөн. Үүнээс маш ойлгомжтой дүгнэлт гарсан. Хоёр, гурван жилийн дотор Монгол Улсын шатахууны хэрэглээний гуравны хоёр хувийг уул уурхай хэрэглэдэг болсон байна. Гурван жилийн өмнө иргэд болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд шатахууны гуравны хоёр хувийг л хэрэглэдэг байсан. Гэтэл өнгөрсөн жил үнэ өсч байна гэдэг шалтгаанаар уул уурхайн шатахууныг татваргүй болгосон. Шууд татаас өгөөд эхэлсэн.

-Хэн өгсөн гэж?

-Засгийн газар. Уул уурхайн салбар нийт шатахууны хэрэглээний 66 хувийг хэрэглэж байхад үлдсэн хэдэн хувийнхан эсэргүүцэл илэрхийлэн жагсч эхэлсэн. Иймд шатахууны үнийг бууруулахын тулд нэмүү өртгийн албан татварыг суллахаар зорьж байна. Энэ асуудлыг УИХ-аар удахгүй хэлэлцэх гэж байгаа. Уг нь уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа манай улсын хувьд онцгой татвар хэвээрээ байж, тэр ч байтугай эрчимтэй хөгжиж байгаа салбарт татварыг нь нэмэгдүүлэх ёстой. Ингэснээр орж ирэх санхүүжилт нэмэгдэж, бусад салбараа дэмждэг. Гэтэл онцгой татвараа тэглэсэн болохоор санхүүжилтгүй болсон. Бидний эдийн засгийн онол дээр маргалддаг гол сэдэв бол Монголын эдийн засгийн урт хугацаанд аль салбар хөгжих ёстой вэ гэдэг асуудал. Монголын хувьд уул уурхайн салбар БНХАУ-ын эрэлтээр хөгжиж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалт, урд хөршийн эрэлтээр хөгжиж байгаа Монголын уул уурхайн салбарынхан татаасаараа татвараа төлж байгаа нь зөв юм уу. Уг нь татвар авч түүгээрээ бусад салбараа хөгжүүлэх ёстой.

-Тэгвэл Монголын эдийн засгийн урт хугацаанд хөгжих гол салбар нь юу вэ?

-Миний бодлоор хөдөө аж ахуй. Хөдөө аж ахуйн боловсруулсан түүхий эд болон уул уурхайн боловсруулсан түүхий эд Монголын хөгжлийн нэг түлхүүр юм. Иймд энэ салбар руу татвар, мөнгөө төвлөрүүлэх, санхүүжилт хийж хөгжүүлэх ёстой. Гэтэл татааслаад сууж байгаа нь буруу.

-Шатахууны үнийн хувьд?

-Монголын нийт импортын 10 хувь шатахууны байдаг. Иймд энэхүү 10 хувьд зориулан ханшийг доош нь бариад байх тусам Монголын эдийн засгийн өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон ажлын байр Эрээн хот руу шилжих болно. Ханш хэтэрхий чанга байвал бид Грекийн араас ч явж магадгүй. Монгол Улс өөрийн нөөцөөсөө ханшаа чангалах тутам Монголд үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний борлуулалт уналтад орно. Өрсөлдөх чадваргүй болно гэсэн үг.

-Шатахууны үнийн өсөлтийн талаар нэлээд ярилаа. Одоо ханшийн талаар сөхье. Үнийн өсөлтөд танай банкнаас цагаа олж интервеец хийгээгүй гэж хэлж байсан. Миний ойлгосоноор танайх интервеец хийж эхэлсэн тул үнийг хиймлээр барьж байна?

-Интервеецийг өнгөрсөн арван-нэгдүгээр сард хийж эхэлсэн. Яагаад эхэлснийг нь бид тайлбарласан. Есдүгээр сард зэсийн үнэ 25 хувиар унаж, Монголын эдийн засаг том шоконд орсон. Үүнийг бид мэдрээгүй. Нүүрсний үнэ ч өмнөх жилүүдтэй харьцуулахад 50-аад хувиар унасан байсан. Ерөнхийдөө бол манай улсын экспортын бүтээгдэхүүний томоохон орон зайг эзэлдэг хоёр бүтээгдэхүүний үнэ буурсан нь томоохон цохилт болсон. Энэ үед Оюутолгойн асуудал нэлээд маргаантай байсан бөгөөд хөрөнгө оруулалт хийсэн гадаадын компаниудын хувьцаа мөн 50 хувиар унасан. Монгол Улс руу орж ирэх валютын урсгал гацах тийшээ хандсан байсан. Иймд Монголбанкнаас аажуухан интервеец хийж эхэлсэн. Гэхдээ ханш сарын гурван хувийн сулралтай бол зах зээлээ зохицуулж байдаг. Гэтэл Монголбанкинд ханшийг бариад байх чадвар байгаа билүү, үгүй билүү. Монгол Улсын валютын нөөц 2.5 миллиард ам.доллар. Гурван жилийн өмнөхтэй харьцуулахад өссөн. Гурван жилийн өмнө Монголын валютын эргэлт долоон миллиард ам.доллар байсан бол өнгөрсөн онд 20 болтлоо өссөн. Иймд энэхүү өсөлтөөр ханшийг тогтоож барина гэдэг мөрөөдөл юм. Харин ханш огцом хөдлөөд эхлэхэд Монголбанк аажуухан хөдөлгөж чадаж байгаа.

-УИХ-ын гишүүд шатахууны үнийг 500 төгрөг байх боломжтой гэж байсан. Энэ талаар?

-Ханшийг тэгж онцлоогүй. Ванга шиг тоо ярих нь зохимжгүй хэрэг л дээ. Мэргэжлийн бидний хувьд ч гэсэн төсөөлөл ярьдаг. Төсөөлөлд нөлөөлдөг нөлөөллийг судалдаг болохоос биш аливаа нэг тооны төлөө явдаггүй. Бид ханш 1400 төгрөг байх нь зөв гэж ярьдаггүй шүү дээ.

-Ханшийг одоо ямар түвшинд байрж байна вэ?

-Монголын эдийн засагт өнгөрсөн нэгдүгээр сарын 6-нд маш том шок орж ирсэн. Шатахуун импортлогч компаниуд үнээ 18 хувиар өсгөж, Засгийн газар болон хэвлэл мэдээллийнхэн шуурхай арга хэмжээ авсны үр дүнд бага хэмжээгээр үнэ буурсан. Гэхдээ хамгийн гол нь хаврын тариалалтыг эдийн засгийн том шок руу татан орууллаа. Иймд ханшийг тогтвортой байлгах үүднээс Монголбанк интервеецийг их хэмжээгээр хийсэн. Гэхдээ үүнийг удаан хугацаагаар барих боломжгүй. Хөгжиж байгаа улсуудын 10-аадынх нь сонгуулийн жилд гадаадын хөрөнгө оруулалт 25 хувиар буурдаг. Энэ бол зүгээр л тоо. Гэтэл Монгол Улсын хувьд нийт валютын орж байгаа урсгалын гуравны хоёр нь болсон. Харин экспорт буюу нүүрс, зэс гуравны нэг нь.

-Энэ хандлага цаашид яах вэ. Сонгууль болтол та бүхэн барьж байх юм уу. Иргэдэд шок өгөхгүйгээр яаж зохицуулах боломж-той вэ?

-Энэ бол Монголбанкны гурван захирлын ярьж байгаа сэдвүүдийн нэг. Байр суурь ойлгомжтой, тодорхой байх ёстой. Эдийн засаг руу том шок орж ирсэн. Гадаад шок нь өнгөрсөн есдүгээр сард тохиолдсон бол дотоод шок нь нэгдүгээр сард болсон. Намуудын бэлэн мөнгө тарааж байгаа нь жамаараа явж байгаа эдийн засгийг огцом огцом хөдөлгөх гээд байна. Ийм нөхцөлд Монголбанкны оролцоо идэвхтэй байх ёстой. Гэхдээ зах зээлийн тогтвортой байдлаа хангах зорилготой оролцох бөгөөд тендер солих бодлого баримтлах юм бол Монголын нөөцийн асуудал

хурцаар тавигдах болно. Монголын улстөрчид сонгуулийн дараа амьдрал, эдийн засаг байхгүй юм шиг аашлах нь аюулын дохио.

-Та Монголбанк бие даасан, чөлөөтэй бодлого явуулах ёстой хэмээлээ. Монгол Улсын эдийн засаг хөгжихийн хэрээр мөнгөний хэрэглээ нэмэгдэх нь ойлгомжтой. Монголбанкны бизнесийн зээлийн хүү 12.25 хувь байдаг. Гэтэл ийм нөхцөлд Засгийн газар бонд гаргаж, дараа нь 200 тэрбум төгрөгийн орон сууцны бондыг дөрөвдүгээр сараас зарахаар боллоо. Энэ нөхцөлд зээлийн 12.25 хувь багадах нь. Үүнийг та юу гэж үзэж байна вэ?

-Энэ жилийн УИХ-аас гарсан инфляцийн төсөөлөл 10 хувь дотор байгаа. Харин одоогийн Засгийн газраас гаргасан шийдвэрийг хараад байхад тэлэлт асар хүчтэй явагдах юм шиг байна. Гэтэл өргөн хэрэглээний барааны үнийг тогтвортой барих ёстой. Гэвч махны үнийн зохицуулалт асар сул байна. Засгийн газрын оролцооны үр дүн гэх зүйл ч харагдахгүй байна. Бэлдсэн нөөц нь хангалтгүй байгаа. Энэ нь иргэдэд маш том ачаалал өгдөг. Үүнийг зохицуулдаг ганцхан механикм байдаг. Тэр нь төгрөгөө эдийн засгаас татаж авах. Энэ бол бодлогын хүү.

-Та Харвардын их сургуульд суралцсан. Хүмүүс яагаад Харвар-дын их сургуулийг сонгодог юм бэ?

-Унгар улсад суралцаж байхдаа Харвардын их сургуулийн тухай мэдсэн юм. Энэ бол эдийн засагч хүний мөрөөдөл. Гэхдээ Харвардын их сургууль бусад сургуулиас 10, 20 дахин илүү биш. Харин энэ сургуулийг төгссөний дараа үүнээс өөр сургууль байхгүй мэт төсөөлж байгаад гол учир нь байгаа юм. Тус сургуулийн багш нарын мэдлэгийн түвшин их өндөр.

-Та сургуультайгаа холбоотой байдаг уу?

-Холбоотой байдаг. Саяхан Монгол Улсад энэ сургуулийн ассиосаци байгуулагдлаа. Энэ сургуулийг төгссөн хүмүүс ч Монголд цөөхөн байдаг. Гэхдээ Монголын хувьд цөөн хүн амтай учир нэг хүнд ноогдох боловсролын түвшингөөрөө өндөр байх ёстой. Чадварлаг сургуулиудад сурах хэрэгтэй. Хоёр хөршөөсөө боловсролын түвшингөөрөө илүү байж Монгол Улс урт удаан хугацаанд оршин тогтноно.

-Яагаад Монгол Улсад сургууль төгссөн хүүхдүүд гадаадад сурах сонирхолтой байдаг юм бол. Эсвэл төрийн байгууллагад ажилд орохоор зүтгэх юм. Ингээд байгаагийн учрыг юу гэж боддог вэ?

-Нийгмийн бүх асуудлыг бид шийддэггүй. Гэхдээ боловсролын хувьд үүнийг дэмжиж ёстой асуудал. Дээд түвшний боловсролд өндөр хөрөнгө оруулалтыг зоригтой хийх ёстой. Улс орны аюулгүй байдлын нэг асуудал нь боловсрол юм. Монгол Улсын ирээдүй хүн бүхнийг мөнгөтэй болгох дээр тулгуурлахгүй.

-Монголбанк үеийн үед чадвартай боловсролтой залуучуудыг авдаг гэдэг ойлголт байх юм. Энэ ямар учиртай юм бол?

-Монголбанкинд ороход онолын маш олон судалгаа хийгддэг. Судалгаа болгон чадвартай боловсон хүчнийг шаарддаг.

-Тийм хүмүүсийг яаж олж байна вэ. Танай вэб сайт сайн ажиллаж

байга а гэсэн үг үү?

-Сүүлийн хоёр жил вэб сайтдаа илүү их анхаарч байгаа. Монгол Улсын гадаад худалдааны тэнцлийг улирал тутамд хэвлэдэггүй байсан. Гэтэл одоо сар тутам гаргаж, вэб сайтаараа дамжуулан олон нийтийн хүртээл болгодог болсон.

-Монголбанкны валютын нөөц аль улсын ямар дансанд байрладаг вэ?

-Валютын хэдэн хувь нь алт, нүүрс, ам.доллар байдаг талаарх дотоод нөөц нь нууцын зэрэглэлтэй байдаг. Өнгөрсөн жил бид алт худалдан авч түүнээс 1.5 сая ам.долларын ашиг олсон.

-Монгол Улс жилд 20 орчим тонн алт олборлодог. Гэтэл багахан хэсгийг нь Монголбанкинд тушааж байна. Бусад алт хаачдаг юм бол?

-Хулгайн асуудал нэлээд их байгаа байх. 68 хувийн татвар тогтооход Монгол Улсад тушаах алт нэг тонн болсон. Харин 68 хувийн татаварыг болиход гурван тонн болж өссөн. Яваандаа 4-5 тонн болох байх.

-БНХАУ-ын мөнгө зах зээлд нь эргэлдэж байгаа цөөхөн улсын нэг нь манай улс. Монгол төгрөгийн болон Хятадын юань хоорондын харьцааг юу гэж үзэж байна вэ?

-Монголын нийт гадаад худалдааны бүтцийг харж байхад 25 хувь нь юаниар хийгдэж байна билээ. Гэтэл юань чөлөөт валют биш. Монголын валютын нөөц гэж яригдаад байгаа 2.2 миллиард ам.долларт юань оролцоогүй. Гэтэл Монголын эдийн засаг дахь юаны хэрэгцээ маш их. Бид үндэсний валют солилцох гэрээ байгуулсан. Энэ хүрээндээ таван миллиард юань татаж, гадаад худалдааны хэрэгцээндээ ашиглах боломжтой болсон.